



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 5/43

Чингис хот

Багш нарыг шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Засгийн газрын 1997 оны "Аймаг нийслэлийн Засаг даргын олгох шагналын тухай" 54 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2003 оны А/99 дүгээр захирамжаар батлагдсан аймгийн "Хүндэт тэмдэг" олгох журам, 2015 оны А/511 дүгээр захирамжаар батлагдсан "Хан Хэнтийн алдартан тэмдэг олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын багш нарын баярыг тохиолдуулан аймаг, орон нутгийн хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан нэр бүхий багш ажилтныг шагнасугай.

2. "Хан Хэнтийн алдартан тэмдэг"-ээр шагнуулах хүмүүсийн нэрсийг нэгдүгээр, Хэнтий аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр шагнуулах хүмүүсийн нэрсийг хоёрдугаар, Засаг даргын нэрэмжит "Жуух бичиг"-ээр шагнуулах хүмүүсийн нэрсийг гуравдугаар, зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 90.000 /ерэн мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010738

Аймгийн Засаг даргын 2020 оны
...10 дугаар сарын 01 өдрийн 8/43
дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Жуух бичиг	4	12.000	48.000
2	Жуух бичиг дагалдах мөнгө	4	10000	40.000
3	Мөнгөний дугуй	4	500	2000
Дүн				90.000

Аймгийн Засаг даргын 2020 оны
...10... дугаар сарын...01...өдрийн...Б/43
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

"Хүндэт тэмдэг"-ээр шагнуулах хүмүүсийн нэрс

№	Овог нэр	Албан тушаал
1	Э.Болормаа	Боловсрол соёл урлагийн газрын хүний нөөц бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
2	П.Энхтуяа	Хэрлэн 4 дүгээр сургуулийн бага ангийн багш
3	Б.Шилэг	Хэрлэн 4 дүгээр сургуулийн бага ангийн багш
4	Д.Мөнхдалай	Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн багш

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 01 өдрийн Б.143
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

"Жуух бичиг"-ээр шагнуулах хүмүүсийн нэрс

№	Овог нэр	Албан тушаал
1	Д.Болорчимэг	Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн
2	П.Болортунгалаг	Хэрлэн 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
3	Ш.Оюунжаргал	Хэрлэн 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
4	Н.Болормаа	Мөрөн сумын цэцэрлэгийн туслах багш

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 01 өдрийн 5/43
дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Жуух бичиг	4	12.000	48.000
2	Жуух бичиг дагалдах мөнгө	4	10000	40.000
3	Мөнгөний дугтуй	4	500	2000
Дүн				90.000